



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2014 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015.03.25 № 393  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ДАРГА Ш.ЭНХБАТ ТАНАА

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагууд нь тайланг хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Нийслэлийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2014 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 359.2 сая төгрөгийн хөрөнгө чанар, хэрэгцээ шаардлага хангаагүй, өмнөх онуудын санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй байхад 136.1 сая төгрөгийг /2012 оны 19.6 сая, 2013 оны 116.4 сая төгрөгийн нэхэмжлэхээр/ шилжүүлж эмийн зардалд тайлагнасан, 88.3 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тайлагнаагүй, үндсэн үйл ажиллагааны орлогын 111.1 сая төгрөгийг төрийн санд төвлөрүүлэхгүй зарцуулсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 113.6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн, 130.9 сая төгрөгийн эм мэнэлэгийн хэрэгслийг бараа материалын дансанд орлого аваагүй зардалд бүртгэсэн, жилийн эцсийн тооллогоор 16.0 сая төгрөгийн бараа материал тоолоогүй, 47.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө биетээр байгаагүй, 2,842.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг давхардуулан бүртгэсэн, 35.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь ангилж бүртгээгүй, 26.8 сая төгрөгийн түрээсийн төлбөр аваагүй, 10.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц. ОЧИРБАТ

1110400393